



Нэгдсэн Үндэстний
Боловсрол, Шинжлэх Ухаан
Соёлын Байгууллага

IPDC МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ЗӨВЛӨЛД ХҮРГҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТАЙЛАН ИЛТГЭЛ СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭЭХИЙН АЮУЛ ЗАНАЛ (2016 ОНЫ 11 ДҮГЭЭР САР, 30 ДУГААР ЧУУЛГАН)

ЕРӨНХИЙ ТОЙМ

Энэхүү тайлан илтгэлийг 2008 оны гуравдугаар сард баталж, 2010, 2012, 2014 онд дахин шинэчилсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба ял шийтгэлгүй үлдээх асуудлаарх” тогтоол шийдвэрийн дагуу Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр (МХХХ)-ийн Засгийн газар хоорондын зөвлөлийн 30 дугаар чуулганд илгээхээр бэлтгэв. Хамгийн сүүлд 2014 онд шинэчилсэн тогтоол шийдвэрийн дагуу “ЮНЕСКО-гийн Ерөнхий захирлын зүгээс МХХХ-ийн Засгийн газар хоорондын зөвлөлд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүл зүйн үйл ажиллагаанд оролцогч нийгмийн сүлжээний идэвхтнүүд ажлаа хийх явцдаа амь насаа алдах, халдлагад өртөх явдлыг зэмлэн буруушаасан судалгаа бүхий тайлан илтгэлийг хоёр жилд нэг удаа болдог чуулганд хүргүүлэхийг Ерөнхий захирлаас хүсэх тухай МХХХ-ийн тогтоол шийдвэрүүдийг үргэлжлүүлэх”-ийг дахин баталсан. Уг тайлан илтгэл нь 2014-2015 онд сэтгүүлчдийн амь насыг хороосон хэргүүд, мөн сүүлийн 10 жилд буюу 2006-2015 онд гарсан амь насаа алдсан сэтгүүлчдийн хэргийг Ерөнхий захирлын зүгээс зэмлэн буруушаасан талаар тоймолсон болно. Уг тайланд гишүүн орнуудын мэдээлсэн эдгээр хэргийн мөрдөн шалгалтын үйл явцын талаарх шинэчилсэн мэдээллийг багтаав.

ЮНЕСКО-гийн бүртгэснээр, сүүлийн 10 жилд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдэлж, мэдээлэл түгээсний төлөө 827 сэтгүүлчийн амь насыг хороосон хэрэг гарчээ. Үүнээс гадна, сэтгүүлчид¹, хүн хулгайлах, дур зоргоор баривчлах, эрүүдэн шүүх, онлайн болон офлайн айлган сүрдүүлэх, сүрдүүлэг дарамтыг даван туулсан, хэвлэн нийтлэлийг хураах, устгахтай тулгарсан олон сэтгүүлчийн эрхийн зөрчлийг дурдаж болно. Эдгээр сүрдүүлэг заналхийллийг даван туулах нь “Тогтвортой хөгжил – 2030” хөтөлбөрийн Тогтвортой хөгжлийн зорилтын 16.10-т заасан “олон нийтийн мэдээлэл авах эрх, үндсэн эрх чөлөөг хангах” талаарх заалтын хэрэгжилтийн үйл явцыг хэмжихэд чухал үзүүлэлт болно. Энэхүү тайлан нь МХХХ-ийн Зөвлөлөөс гаргасан “Сэтгүүлчдийн аюулгүй байдал болон ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх” 2008 онд гаргасан тогтоол шийдвэрийн дагуу эрхийн хамгийн ноцтой зөрчил болох сэтгүүлчийн амь насыг хороох гэмт үйлдлийн талаар онцолсон юм.

ЮНЕСКО бол НҮБ-ын системийн дотор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөний асуудалд үйл ажиллагаагаа чиглүүлдэг “үзэл бодлын чөлөөт урсгалыг үгээр болон дүрсээр илэрхийлэхийг хөхиүлэн дэмжих” тэргүүлэгч байгууллага юм. Уг байгууллага нь 2012 онд НҮБ-ын сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад чөлөөт, аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн НҮБ-ын системийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө болох “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий байгууллага юм.

¹ Уг тайлан илтгэлд МХХХ-ийн Зөвлөлөөс 2014 онд баталсан “Сэтгүүлчдийн аюулгүй байдал болон ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх” тогтоол шийдвэрийн дагуу “сэтгүүлч” хэмээх нэр томъёо нь “сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, олон нийтийн эрх ашигт үйлчилсэн сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэгч нийгмийн сүлжээний идэвхтнүүд”-ийг хамааруулна.

А. 2014-2015 онд болон сүүлийн арван жилийн хугацаанд амь насаа алдсан сэтгүүлчдийн талаарх тойм мэдээлэл

Зөвхөн 2014-2015 онд 213 сэтгүүлч амь насаа алджээ. 2015 онд гаргасан 2 дахь арван жилд нас барсан сэтгүүлчдийн жагсаалт бүртгэлээс 115 сэтгүүлч бусдын гарт амь насаа алдсан байна. Найман сэтгүүлчийн үхэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг санаатай чиглэсэн урьд өмнө нь гарч байгаагүй халдлага байсныг тэмдэглэсэн байна². 2014 онд ЮНЕСКО-д 98 сэтгүүлч алагдсан хэрэг бүртгэгдсэн.

2014-2015 онд Арабын Улсын бүс нутагт алагдсан сэтгүүлчдийн тоо хамгийн олон бүртгэгдсэн буюу 78 сэтгүүлч алагдсан нь нийт ийм тохиолдлын 36,5% -ийг эзэлж байна. Уг бүс нутгийн хэд хэдэн оронд зөрчилдөөнт нөхцөл байдлаар энэ үйлдлийг тайлбарлаж болно. Латин Америк, Карибийн улс орнуудад 51 сэтгүүлч (24%), Ази, Номхон далайн бүс нутгийн 34 сэтгүүлч (16%); Африкт 27 сэтгүүлч (12,5%); Төв болон Зүүн Европын 12 сэтгүүлч (6%); Баруун Европ, Хойд Америкт 11 сэтгүүлч (5%) амь насаа алдсан байна. Сүүлийн арван жилийн хувьд сэтгүүлчдийн аллагад өртсөн эрсдлийн түвшингээрээ 2-рт багтаж буй бүс нутагт Ази, Номхон далайн бүс нутаг орж байгаа ч, 2014-2015 оны хувьд авч үзвэл Латин Америк, Карибын тэнгисийн улс орнууд орж байна³.

Амиа алдсан эмэгтэй сэтгүүлчдийн тоо бага зэрэг нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл, жил тутамд есөн сэтгүүлчээр харьцуулахад өмнөх жилүүдээс дунджаар дөрөв нь эмэгтэй сэтгүүлч байна. Гэхдээ эрэгтэй сэтгүүлчид амь насанд халтай халдлагын хохирогчдын дийлэнх олонх болсон хэвээр байгаа юм. 2014-2015 онд алагдсан сэтгүүлчдийн бараг 92% нь эрэгтэй байна. Амь насаа алдсан сэтгүүлчдийн талаарх тоо баримт нь мөсөн уулын зөвхөн орой нь бөгөөд эмэгтэй сэтгүүлчдийн хувьд бэлгийн дарамт, хүчирхийлэл зэрэг жендэрт суурилсан аюул заналтай тулгардаг хэдий ч эдгээр нь уг тоон үзүүлэлтэд тусгагдаагүй юм.

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд дийлэнхдээ хэвлэмэл хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийн эсрэг чиглэсэн аллага байв. Харин 2014-2015 онд амь үрэгдсэн сэтгүүлчдийн дийлэнх нь телевизийн сэтгүүлч байсан юм. 2014 онтой харьцуулахад ердөө хоёр байснаа 2015 онд 21 тохиолдол (18%) болж амь үрэгдсэн онлайн сэтгүүлчдийн тоо⁴ огцом өссөн. Амь насаа алдсан эдгээр сэтгүүлчдийн тэн хагас нь Сири дэх мөргөлдөөнт нөхцөл байдлыг сурвалжилж буй Сирийн сэтгүүлчид, блогчид байна.

Сүүлийн арван жилийн турш ажиглагдсан чиг хандлагыг баталж, 2014-2015 онд хохирогчдын бараг 90% нь нутаг орны сэтгүүлчид болж байна.

Хараат бусаар ажилладаг болон байнгын хангалттай хамгаалалтгүй чөлөөт сэтгүүлчид хэвлэл мэдээллийн салбарын хамгийн эмзэг бүлэгт ордог. Онлайн хэвлэл мэдээлэлд ажиллаж байгаа чөлөөт эсвэл иргэний сэтгүүлчдээс 2014-2015 онд 40 сэтгүүлч амь насаа алдсан буюу 19%-ийг (2006-2015 онд ажиглагдсантай ижил хувь хэмжээтэй байна) эзэлж байна. Зөрчил мөргөлдөөнт бүсэд ажиллаж буй сэтгүүлчдийн туйлын эмзэг байдлын тусгал нь болсон нийт амь насаа алдагдсадын 59% -д буюу 126 тохиолдол нь зэвсэгт мөргөлдөөн гарч байгаа улс оронд бүртгэгджээ⁵.

² Францын Шарли Ебдо сэтгүүлчийн эсрэг халдлага, 2015 оны 1 сарын 7, Парис, Франц Улс

³ Уг тайлан илтгэл дэх бүсчлэл нь ЮНЕСКО-гоос ангилсан газар зүйн бүсийн ангилал болно

⁴ Эдгээр нь онлайн ХМХ-д ажилладаг сэтгүүлчид, сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэгч нийгмийн сүлжээний идэвхтнүүд болно.

⁵ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын дайны зөрчилдөөнт бүс болох Афганистан, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Колумб, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Ирак, Ливи, Мали, Мьянмар, Нигер, Палестин, Сомали, Өмнөд Судан, Сири, Украин болон Йемен улс дахь энгийн иргэдийг хамгаалах талаарх 11 болон 12 дахь тайлан илтгэл (Тайлан илтгэлийг 2015 оны 6 сар, 2016 оны 5 сард НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд илтгэсэн)

Б. Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудалд анхаарал хандуулах нь: ЮНЕСКО-гоос мэдээлэл авах хүсэлтэд өгсөн гишүүн орнуудын хариу

Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийллийн мөчлөгийг байнга илэрхийлж буй сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйтай тэмцэх чухал алхам нь өндөр түвшинд хүрээд байгаа амь алдсан сэтгүүлчдийн хэргийг шийдвэрлэхэд чиглэж байна. Энэ нь ЮНЕСКО-гийн Ерөнхий захирлын зорилтын нэг болохын хувьд 2008 онд батлагдсан “Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба ял шийтгэлгүй үлдээх асуудлаарх” тогтоол шийдвэр болон МХХХ-ийн Засгийн газар хоорондын зөвлөлийн дараа дараагийн шийдвэрүүдээр амь насаа алдсан сэтгүүлчдийн хэргийг шийдвэрлэж буй байдлыг ЮНЕСКО-гийн зүгээс зэмлэн буруушаан, гишүүн улс орнуудаас энэ талаар мэдээлэл хүссэн байна.

Бүхэлд нь авч үзвэл, МХХХ-т Ерөнхий захирлын илгээдэг тайлан илтгэлд зориулан ЮНЕСКО-гоос 2006 оноос хойш 2015 оныг дуусталх хугацаанд амь насаа алдсан сэтгүүлчдийн талаарх мэдээллийн хүсэлт гаргаснаас хойш 70 гишүүн улсаас 59 нь сэтгүүлчдийн амь насаа алдсан хэргийн мөрөөр дор хаяж нэг хэргийг шалгасан тухай мэдээлэл ирүүлж, үлдсэн 11 улс орон хариу огт ирүүлээгүй байна.

ЮНЕСКО-гийн Ерөнхий захирлын анхаарал хандуулсан сэтгүүлчдийн амь насанд халдсан үйлдлийг шүүн шалган, тогтоож буй байдлын талаар гишүүн орнуудаас хүлээн авсан хариу энэ жил нэлээд өссөн нь мэдээллийн хүсэлтэд гарч буй тэмдэглүүштэй алхам байв. Ерөнхий захирлын хүсэлтэд улс орнуудын бараг 65% (өөрөөр хэлбэл, 62 орноос 40-д) анхаарч ажилласан хариу ирүүлсэн бөгөөд өмнөх онуудын тайлантай харьцуулахад 2014 онд 27% (59 орноос 16 нь), 2015 онд улс орнуудын 47% (57 орноос 27 нь) байжээ. Энэ чиг хандлага нь МХХХ-ийн хяналт-шалгалтын механизмын ач холбогдлыг гишүүн улс орнууд хүлээн зөвшөөрөх явдал өсөн нэмэгдэж, сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдсэн гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйд анхаарал хандуулах шаардлагатай болохыг харуулж байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд үйлдэгдсэн 827 хэргээс Ерөнхий захиралд 59 гишүүн орноос 402 хэргийн талаар мэдээлэл ирүүлсэн байна. Гэвч эдгээр хэргийн зөвхөн 63 нь шийдвэрлэгдсэн нь мэдээлэл ирүүлсэн хэргийн 16%, харин нийт хэргийн дөнгөж 8% болж байна. Мэдээлэгдсэн үлдэж буй 339 хэрэг (нийт хэргийн 40%) нь мөрдөн шалгах шатандаа явж байгаа эсхүл бүртгэгдээд орхисон, огт шийдвэрлэгдээгүйд тооцогдож байна. Эцэст нь, 425 хэргийн талаар буюу 51% нь ямар ч мэдээлэл байхгүй, эсвэл хэрэг үйлдэгдсэн гишүүн орноос Ерөнхий захирлын хүсэлтийг хүлээн авсан хэмээн мэдэгдсэн.

Хянан шийдвэрлэсэн 63 хэргийн 20 нь Латин Америк, Карибийн орнууд (бүс нутгийн нийт хэргийн 11%-ийг эзэлж байна), 14 нь Төв болон Зүүн Европ (39%-ийг эзэлж байна), 13 нь Ази, Номхон далайн бүс нутаг (6%-ийг эзэлж байна), 8 нь Баруун Европ, Хойд Америк (57%-ийг эзэлж байна), 4 нь Африк (4%-ийг эзэлж байна) болон үлдсэн дөрвөн хэрэг нь Арабын бүс нутаг (1,5%)-т хамаарч байна.